

Ц. Уртнасан

Социологийн ухааны доктор (Ph.D)

АМЕРИК ДАХЬ МОНГОЛЧУУД

Abstract: Along the core changes in politics, economics, opinions in Mongolian society, lives of people, their opinions, belief, wills are also changing. Sociology scientifically analyzes problems in society and defines ways to solve them. We bring the results 289 responds from a study conducted among 800 people living in America through mails.

Key words: America, Mongolia, salary, labor, education, hardship, opinion.

Монголын нийгмийн улс төр, эдийн засаг, үзэл санаанд гарсан язгуур өөрчлөлтийг дагалдан хүмүүсийн амьдрал ахуй, үзэл бодол, итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл зэрэг бүхий л үйлдэл шинэчлэгдсэн юм. Хүн болгон амьдрах газраа чөлөөтэй сонгоно гэсэн Үндсэн Хуулийн заалт амьдралд хэрэгжин хөдөөнөөс хотод шилжихдээ түмэн бэрхшээлийг туулж байсан монголчууд гадаадын аль ч улс оронд чөлөөтэй зорчих, тэр тусмаа амьдрах бололцоотой болсон билээ. Энэ бололцоо бодит байдал болж олон мянган залуучууд гадаадад ажиллаж амьдрах болсоноор тодорхой айл өрхийн эдийн засгийн чадавх нэмэгдсэн төдийгүй манай орны эдийн засагт ч нөлөөлж байна. Албан бус мэдээллээр зөвхөн Солонгос улсад ажиллаж байгаа Монголчууд жилдээ ... сая долларыг эх орондоо гуйвуулдаг аж. Үүнээс гадаадад ажиллаж, амьдарч буй монголчуудын «гавьяа» бага ч гэсэн мэдрэгдэнэ. Гэхдээ тэд нар маань яаж ажиллаж амьдарч, ямар зовлон бэрхшээл амсч буйг бид тэр болгон мэддэггүй. Тэдний санал бодлыг үр ашгийг нь хүртэж буй хүмүүс ч, төр засаг ч мэддэггүй.

Нийгмийн амьдралд тулгарч буй аливаа асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судалгаагаар задлан шинжлэж шийдвэрлэх боломж нөхцөл, арга замыг тодорхойлдог. Тийм учраас 2005 оноос Америкт амьдарч байгаа Монголчуудын санал хүсэлтийг боломжийн хэрээр судлаж байгаа юм. АНУ-ыг сонгосон нь манай байгууллагын ашиглаж болох боломж, хувийн харилцааг гол болгосонд оршино. “Гадаад дахь Монголчууд” гэсэн төслийг зохих журмын дагуу эрдэм шинжилгээний судалгаанд багтааж өгөхийг хүссэн боловч өдий хүртэл хэрэгжээгүй учир бид урьдын адил хувийн харилцаанд тулгуурласан хэвээр байгааг дахин тэмдэглэе. Бид энэхүү судалгааг АНУ-д ажиллаж амьдарч байгаа 800 гаруй хүний дунд шуудан, захидлын аргаар явуулж 289 хүний хариултад тулгуурлан нэгтгэн дүгнэж байна. Энэхүү судалгааг явуулахад бүх талын тусламж үзүүлсэн “Америк дахь Монголчууд” нийгэмлэгийн тэргүүн Б.Номинчимэд, мөн АНУ дахь Монголын элчин сайд асан Р.Болд нарт гүн талархсанаа илэрхийлж байна. Одоо судалгааны дүнг танилцуулая!

I. Монголчууд яагаад Америкт явдаг вэ?

Монголын нийгэм нээлттэй болсоноор хэрэгжиж эхэлсэн гадаадад ажиллах амьдрах боломж айл өрх, бие хүн болгонд онцлог байдлаар илэрдэг. Явах болсон шалтаг шалтгаанаа амьдрал ахуйгаа дээшлүүлэх, гэр бүлээ тэжээж тэтгэх (42.1%), суралцахын зэрэгцээ ажиллах (мөн 42.1%), хөгжилтэй оронд ажиллаж амьдрах (21.4%), их мөнгө олох (13.8%) гэж судлагдагсад үзсэн байна.

Нийгмийн шинэ орчин нөхцөлд хүмүүс тэр болгон хурдан дасч чадаагүйн улмаас үүссэн амьдралын түвшний доройтол, цочирдон балмагдах байдлаас гарах нэг арга зам бол гадаадад гарч ажиллаж амьдрах явдал байсныг энэ судалгааны дүн харуулж байна.

1.1. АНУ-д ямар шугамаар очдог вэ?

Алс холын америк ойрхон болж элдэв арга хэлбэрээр тийшээ явахыг эрмэлздэг боллоо. Гэхдээ хүн болгон америк явахыг хүсдэггүй, тэр орныг диваажин гэж ойлгохоосоо илүү эх орон, нутаг усаа дээдэлсэн монголчууд маш олон.

Манай орны шинэ үеийн залуучуудын гадаадад ажиллаж, суралцах боломж улам бүр нэмэгдэж байна. Монгол оронд хэрэгжсэн ардчилсан хувьсгалын үр дүнд манай орныг дэмждэг, хандив тусламж олгодог улс орон нэмэгдэж, олон улсын байгууллагууд буй болсон төдийгүй тэдгээртэй холбодог, жуучилдаг байгууллагууд дотооддоо төдийгүй гадаадад хүлээн зөвшөөрөгдөх төвшинд хүрсэн юм. Тийм ч учраас америкт явагсадын 39.0 хувь нь суралцахын тулд, 18.1 хувь нь америкаас явуулсан урилгыг (өөрсдөө өргөдөл гаргаж шаардлагад тэнцсэн,

эсвэл, ах дүү төрө садан нь урисан, урилга бүтээсэн) үндэслэж, 17.8 хувь нь тодорхой хүмүүст мөнгө төлж иржээ. Харин энд ирээд эрхэлж байгаа ажил төрлийг ирсэн зорилготой нь харьцуулахад бага зэрэг ялгаа харагдаж байна.

1.2. Америкт ажиллаж ч, суралцаж ч болно

Судалгааны дүнгээс үзэхэд Америкт очсон монголчуудын дийлэнх нь (66.0%) ажил эрхлэж, дөрвөн хүн тутмын нэг нь (23.5%) суралцаад ажиллаж байгаа юм. Амьдралын өртөг өндөр, сургалтын төлбөр их болохоор зөвхөн суралцаж байгаа хүмүүс цөөн (4.6%) байх нь аргагүй. Өмнө дурдсан төрөл бүрийн шугамаар америкт очиж суралцагсадын сайндаа л жилийн төлбөрийг ихэвчлэн эхний семестрийн төлбөрийг даагаад зөнд нь орхидог явдал олонтаа тохиолддог. Тийм учраас сургуулиа орхих эсвэл суралцахын зэрэгцээ ажиллаж төлбөрөө олдог байна.

Манай хоёр орны харилцаа улам өргөжиж хөрөнгө оруулалт, тэтгэлэг, буцалтгүй тусламж, худалдааны хөнгөлөлт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа нэмэгдэж байгаа нь олзуурхах зүйл мөн. Харин өндөр мэргэжилтэй ажиллах хүчинг бэлтгэх зорилгод чиглэсэн төрийн бодлого тун цэгцтэй бөгөөд тасралтгүй үргэлжлэх чанарыг хангасан баймаар юм. Ядахдаа америкийн иргэдтэй ойролцоо хэмжээний (гадаадын иргэд 2-3 дахин их сургалтын төлбөр төлдөг) төлбөр төлөх асуудлыг дэвшүүлэн шийдвэрлэж болмоор санагдана.

Америкт ирээд ажиллах, суралцах сонголт нь эх нутагтаа ямар ажил алба эрхлэж байснаас хамаарах нь зүйн хэрэг.

Монголд эрхлэж байсан ажил алба (хувиар)

1. Төсвийн байгууллагад ажиллаж байсан	25.7%
2. Их дээд, ЕБС-д суралцаж байсан	21.2%
3. Пүүс, компанид	19.8%
4. Хувиараа хөдөлмөр эрхлэж байсан	13.9%
5. Бусад (ТББ, ганзгын наймаа, ажилгүй г.м)	19.4%

Эх орондоо суралцаж байсан болон одоо америкт суралцаж байгаа хүмүүсийн хувийн жин ойролцоо байгаагаас үзэхэд тэд үргэлжлүүлэн суралцах зорилгоо биелүүлж байна. Судалгаанд хамрагдсан суралцаж, эсвэл суралцаад ажиллаж байгаа хүмүүсийн дундаж нас 23 байхад ажиллагсдынх 29 байгаа нь дээрх дүгнэлтийн үндэслэгээ болно. Төсвийн болон бусад байгууллагад ажиллаж байсан хүмүүс ихэвчлэн ажил эрхлэдэг байна.

1.3. Хэн америк явж байна вэ?

Америкт амьдрах хүсэл сонирхол монголд богино хугацаанд түргэн тархаж нэлээд тооны хүмүүс явцгаасан бөгөөд албан бус баримтаар 100-аад мянган монголчууд Америкт амьдарч байгаа нь Солонгосын дараа хоёрт орж байгаа юм.

Бидний судалгаанаас үзэхэд бараг бүх насны хүнийг жигд хамарч байна. Тухайлбал, насны ангилал бүрт (16-25 насныхан 18.9%, 26-30 насныхан 20.7%, 31-35 насныхан 19.6%, 36-40 ба 41-60 насныхан тус бүр 20.4%) ойролцоо хувь эзлэж байна.

Боловсролын хувьд дийлэнх нь дээд (73.3%) ба бүрэн дунд боловсролтой (21.7%) хүмүүс зонхилж эмэгтэйчүүд ялимгүй илүүтэй ч манай хүн амын ерөнхий харьцаатай (эр 49: эм 51) ижил байна.

Төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг америкт очсон хүмүүс төлөөлж байгаа юм. Эрхлэж буй ажил хөдөлмөр, эзэмшсэн боловсрол мэргэжлийн шинжээс хамааран гэр бүлийн хэн нэгэнд нь явах боломж олоод дараа нь хань ижил, үр хүүхэд, аав ээж, ах дүүгээ татдаг учир нийгмийн бүлэг давхраа, насны хамаарал байхгүй байна. Харин боловсролын төвшин мэдэгдэхүйц нөлөөтэй байна.

II. Америкт монголчуудын эрхлэж буй ажил, хөдөлмөр

II.1. Эрхлэж буй хөдөлмөрийн онцлог

Америкт очсон Монголчууд төрөл бүрийн ажил, хөдөлмөр эрхлэж боломжийн хэмжээнд амьдрал ахуйгаа аваад явж чаддаг. Дэлхийд алдартай Microsoft компанид программ зохиож, АНУ-ын үндэсний ШУА-ийн харьяа лабороторид биотехнологийн чиглэлээр төсөл удирдаж буй монгол залуучууд байдаг. Ер нь америкийн аль ч хотод тодорхой бизнес эрхлэж түнш, үйлчлүүлэгчтэй болсон монголчууд элбэг тохиолдоно. Тэд хот хооронд ачаа тээвэр зөөвөрлөх, эмнэлэгийн үйлчилгээ эрхлэх, хоолны газар ажиллуулах, ажил зуучлах зэрэг хөдөлмөр эрхлэж ойр орчмын уугуул иргэдийн танил болсон төдийгүй тэдгээрээс хүн авч ажиллуулах тохиолдол ч байдаг. Хэдийгээр ийм хөдөлмөр эрхлэх эрх бүхий монголчууд ховор ч гэсэн америк руу цагаачлаж эхэлсэн монголчуудын хориодхон жилийн түүхтэй харьцуулвал

манай ард түмний хөдөлмөрч ухамсарлал, хаана ч гэсэн амьдарч чадах үндэсний дасан зохицох чадварын илрэлийг харуулж байгаа юм.

Тэнд очсон монголчууд ихэвчлэн биеийн хүчин голлосон (48.3%) ба үйлчлэх зохицуулах хөдөлмөр (35.1%) эрхлэдэг байна. Хэдийгээр өөрсдийн эзэмшсэн мэргэжил боловсролоо ашиглах шаардлагагүй ажил хөдөлмөр эрхлэдэг ч (судлагдагсадын 66.9% нь ингэж хариулсан) гэсэн тэд эрхлэж буй ажил хөдөлмөр болон авч буй цалин хөлсөндөө сэтгэл ханамжтай байгаа юм.

Эрхлэж буй ажил хөдөлмөртөө судлагдагсадын 50 орчим хувь нь сэтгэл ханамжтай, 10.1 хувь нь тааруу гэсэн үнэлгээ өгчээ. Үүнээс үзэхэд америкт ажиллаж буй монголчуудын хөдөлмөрийн сэтгэл ханамжийн төвшин нэлээд сайн байна. Хэдийгээр тэд биеийн хүчний болон үйлчлэх зохицуулах хөдөлмөр голлон эрхлэдэг боловч тэдний хөдөлмөрлөх нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалт сайн байдаг учир ийм үнэлгээ өгсөн байх.

Нөгөө талаар ийм төрлийн хөдөлмөр манай оронд хэрхэн гүйцэтгэдэгтэй харьцуулан дүгнэсэн нь лавтай.

II.2. Байнгын ба түр хөдөлмөр эрхлэлт

Нэгэнт биеийн хүчин голлосон ба үйлчлэх хөдөлмөр эрхлэхээс өөр аргагүй ч гэсэн хаана ямар ажил хийвэл ажлын ачаалал, авдаг цалингийн хувьд ашигтай байх бол гэдгээ монголчууд сайн мэднэ. Эхний үед тохиолдсон боломж нөхцлөөс шалтгаалан ямар нэгэн ажилд хурдан ороод хэсэг хугацааны дараа түүнийгээ солих явдал элбэг тохиолдоно. Манай судлагдагсадын 34.9 хувь нь ажилаа 1-2 удаа, 33.2 хувь нь 3-5 удаа, 13.1 хувь нь 5-аас дээш удаа сольсон байна. Ингэхээс ч өөр аргагүй. Амьдрал, ахуйтай сайн танилцаж амжаагүйн дээр хэлний мэдлэг чадварын дорой төвшиндөө баригдан эхний үед олдсон ажлыг яаравчлан хийдэг. Энэ ажлыг ихэвчлэн тэнд суурьшсан монголчууд бие биенээсээ дам сураглан олж өгдөг юм.

Яваандаа байдал өөрчлөгдөн америкт амьдрах арга ухаан сууж, амьдралын зорилгоо арай ондоогоор төсөөлөх болсон үедээ эхний ажил хөдөлмөрөө өөрчлөх ёстойг ойлгоно. Тийм ч учраас ажилаа өөрчлөх явдал түгээмэл байдаг. Нөгөө талаар нэг газар тогтвор суурьшилтай ажиллах хүсэл сонирхол манайх шиг дэлгэр биш тэр тусмаа америкийн цагаачдад энэ бол бараг хамааралгүй асуудал.

Одоогийн эрхлэж буй ажил хөдөлмөртөө сэтгэл ханамжтай байгаа хэдий ч ажилаа өөрчлөх хүсэл бас байгааг судалгааны дүнгээс харж болно.



Судлагдагсдын 57.9 хувь нь ажилаа өөрчлөх сонирхолтой байгаа бол 13.0 хувь нь солихгүй, 26.7 хувь нь одоогоор солино гэсэн бодолгүй аж. Энэ бүгдээс дүгнэхэд америкт очсон монголчууд эхний үед олдсон ажлыг хийж байгаад дараа нь өөрсдийнхөө боломж нөхцлийг тооцож ажил хөдөлмөрөө сонгодог байна. Тэр тооцоонд эрхлэх хөдөлмөрийн шинж чанар буюу хийж гүйцэтгэх үйлдэл, авах цалингийн хэмжээ, ажил гэр ойролцоодуу байх зэрэг ордог юм.

Ажил завсардалтын хугацаа дунджаар төдийлөн удаан бус сайндаа л нэг сар болдог бололтой. Гэхдээ үүнээс урт үргэлжлэх явдал тохиолдох боловч төдийлөн түгээмэл байдаггүй. Ямарч л байсан нутагтаа байдаг шиг удаан хугацаагаар ажилгүйчүүдийн эгнээнд орохгүй, ажилаа сольж холин байдаг ч гэсэн ажил олох боломжтой.

II.3. Тэд хэдэн доллараар цалинждаг вэ?

Америкт хөдөлмөрийн хөлсийг ихэвчлэн цагаар тооцож долоо хоног тутам цалинг нь олгодог. Ялангуяа үйлчлэх зохицуулах хөдөлмөр эрхлэдэг хүмүүст энэ нэлээн түгээмэл. Манай судалгаанд хамрагдагсадын 38.4 хувь нь цагт 8 хүртэл доллараар, 39.1 хувь нь 9-12, 12.3 хувь нь 13-15, 7.0 хувь нь 16-аас дээш доллараар нэг цагт цалинжиж байна. Гаднаас янз бүрийн арга хэлбэр, нөхцөл боломжийг ашиглан (цагаачлаж) ирсэн, албан бичиг баримт, оршин суух зөвшөөрөлгүй (хараар) амьдарч байгаа хүмүүст хамгийн доод хэмжээний цалин өгөх нь

мэдээж. Гэхдээ хамгийн бага нь гэхэд л 30-50 долараар цалинжих нь амьдралын наад захын хэрэгцээгээ (байрны түрээс, хоол унд г.м) элбэг хангадаг. Үүнээс дээш хэмжээгээр цалинжиж байгаа хүмүүс бүр ч боломжийн амьдралтай. Тогтсон ажил төрөлтэй бол *лизингийн* зээл авч хаус, машин г.м үл хөдлөх хөрөнгөтэй болж, аав ээж, ах дүү нартаа доллар илүүчлэж байгаа нь тодорхой өрх гэрийн амьдралд нэмэр болох төдийгүй дам байдлаар улсын валютын хэмжээ, эдийн засгийн чадавхид ч нөлөөтэй.

Тийм ч учраас авч буй цалингийнхаа хэмжээнд сэтгэл ханамжтай байдаг. Тэдний дийлэнх нь (53.9%) зарцуулсан хөдөлмөртэйөө таарсан цалин авдаг гэж үнэлжээ. Харин дөрвөн тутмын нэг (26.1%) нь зарцуулсан хөдөлмөрөөсөө бага цалин авдаг, ер нь цалин бага гэж зургаан хүний нэг (17.3%) нь хариулсан байна.

III.4. Тэдний эрхлэж буй хөдөлмөрийг Монголд хэрэгжүүлэхийн тухайд

Олон мянган залуучууд гадаадад ажиллаж амьдарч байгаа боловч тэд хэзээ нэгэн цагт эх нутагтаа эргэж ирэх нь магад. Тэд эргэж ирээд Монголд хэрхэн яаж амьдрах, өөрсдийн эрхлэж буй ажил хөдөлмөрийг хөгжүүлж болох эсэх талаар өөрийн бодол санаатай явцгаадаг. Тэдний 66.7 хувь нь тухайн ажилаараа хувийн хөдөлмөр эрхлэх (26.6%), жижиг, дунд аж ахуй үүсгэх (20.4%), ийм төрлийн ажил үйлчилгээг монголдоо шинээр үүсгэх (19.7%) бодол санаатай байна. Харин тэд ажиллах чадвар, аж ахуй эрхлэх хуримтлуулсан хөрөнгө, хийж бүтээх насныхаа үед ирэх эсэхэд олон хүчин зүйл нөлөөлнө. Мөн манай оронд үйлдвэр аж ахуй эрхлэх зөвшөөрөл олгох олон журмыг тэд дааж давж гарах эсэхээс бас хамаарна. Үүнийг дааж чадаагүй ганц хоёр хүмүүстэй бид уулзалдаж байсан учир эмзэглэж байгаа юм.

III. Монголчуудын бодлоор Америк

III.1. Анхлан ирээд тохиолдсон бэрхшээл

Хүний нутагт анх очиж байгаа хүмүүст түмэн бэрхшээл тохиолдох нь ойлгомжтой. Манай судлагдагсадын 40.4 хувь нь хэл мэдэхгүй, 33.3 хувь нь эрүүл мэнд нийгмийн баталгаа байхгүйн; 24.4 хувь ажил олдохгүй, 15.4 хувь нь нутагаа санахын зовлонг бие сэтгэлээрээ амсаж байжээ. Энэ ч аргагүй л монгол хүний сэтгэл зүйн онцлогийг илэрхийлж байгаа юм. Тэд өвчин эмгэггүй байж, ажил төрөл эрхлэхивэл болно гэдгийг л чухалчилсан байна.

Гэтэл цаг наргүй ажиллах, хоол хүнсээр дутагдах, хүнд бохир ажил хийвэл яана гэсэн айдас, болгоомжлол 2.5-10.5 хувьд нь тохиолджээ. Ийм хэлбэрийн бэрхшээлийг манайхан юм чинээ бодож тоодоггүй, даваад гарч чадна гэсэн итгэлтэй байдгийг харуулж байна.

Нүүдэлчдийн амьдралын хэв маяг үйлдвэржсэн, хотожсон суурин амьдралтай зохицдоггүйгээс, мөн хүнч сэтгэл, тусархаг хамтач зан харилцаанд дасчихсан монголчуудад «америкчуудын хуурмаг инээмсэглэл»-ээр далдлагддаг харилцаа таалагддаггүй бололтой.

III.2. Манайханд Америкийн юу нь таалагддаг вэ?

XXI зууны монголчууд «хуучин хүү»-г бодвол юм үзэж, нүд тайлсан соёл боловсролтой шинэ хүн болж төлөвшиж чадсан. Тэд дэлхийн аль ч улс оронд очсон ч тэндхийн амьдралын хэв маягт хурдан дасч, хэл соёлыг нь дагаж амьдардаг.

Дуурайх сайн зүйлийг ч соргогоор тусган авдаг билээ. Тэнд амьдарч байгаа монголчуудад нэн түрүүн хөгжил дэвшил (49.3%), харилцааны соёл (22.1%), дэд бүтэц замын сүлжээ, амьдрах боломж орчин, хуулиа ягштал баримталдаг (16.0%-18.2%) чанар ихэд таалагдсан байна. Хүн өөрт нь байдаггүй зүйл рүү тэмүүлдэгийн үлгэрээр манай оронд дутагдаж буй хөгжил дэвшлийн хурдац, улс төржсөн хэрүүл шуугиантай харилцаа, амьдралын төвшингийн доройтол, энхэл донхол зам, замын түгжрэл, хууль гууль болсон зэрэгтэй харьцуулан үзсэн нь мэдээж хэрэг.

III.3. Таалагдаагүй зүйл

Эх орноосоо алс хол нутагт тэр тусмаа ардчилал эрх чөлөө, амьдрал ахуй цэцэглэсэн гэгддэг Америкт очоод «их санасан газар ес хоног хоосон» гэдгийн үлгэр яг тэр чигээрээ таарахгүй ч гэсэн сэтгэлд таагүй зүйл тохиолдох нь гарцаагүй. «Америкт ирсний дараа Танд юу нь таалагдсангүй вэ?» гэсэн асуултанд судлагдагсадын 40.4 хувь нь гадуурхуу, ихэмсэг, хуурамч зантай гэж хариулжээ.

Үүний дараа амьдралын өртөг өндөр, бичиг баримтгүй, ажил олдохгүй, хэлний мэдлэгийн дутмаг байдал зэрэг бэрхшээл тохиолддог гэжээ. Эх орон, элгэн саднаасаа хол амьдарч байгаа болохоор бэрхшээл төвөг учрах нь мэдээж боловч манайхан тэр болгоныг даван боломжийн хэмжээнд амьдарч байгааг бахархууштай санагддаг.

Хөрөнгө мөнгөнд тулгуурласан, хар амиа бодох үзэл давамгайлсан америк амьдралын хэв маяг манай хүмүүст тун хурдацтай хэвшиж байгаа ч гэсэн үндэсний болон хүн хүнээ

хайрлах нинжин сэтгэл бид бүхэнд байгаа бөгөөд ямагт байгаасай л гэж залбирнам. Тийм ч учраас дээрэнгүй хуурмаг зан монголчуудад таалагддаггүй байна.

Ер нь аливаа үндэстэн уламжлал, шинэчлэлийн зохистой харьцааг хэрхэн баримтлахаас тухайн улс үндэстний ирээдүй хамааралтай. Дэлхийн хөгжилтэй улсуудын тэргүүн эгнээнд ордог япон, солонгос гэх мэт оронд үндэстний уламжлалаа хэвээр хадгалж буйг бид бэлхнээ л харж байна. Уламжлалаа хадгалж байгаа гээд хоцрогдсон хуучныг ягштал баримтлах, шинэ цаг ирж байгаа гээд бусдыг дууриаж хөөрцөглөхийн аль аль нь явуургүй.

III.4. Америкт очсон монголчуудын амьдралын хэвшил, үзэл бодолдоо хийсэн шинэчлэл

Гэр орноосоо холдож амьдралтай танилцаж хэрсүүждэг нь хүний ёс. Аймгаасаа гарч үзээгүй хүүхдүүд арван жилээ төгсөөд амьдралын зам мөрөө хөөж ухаажин амьдралын хэв маяг, дэврүүн сэтгэлийнхээ аль алийг нь өөрчлөж эхэлдэг. Шинэ орчин, шинэ нөхцөл байдал шинэчлэл өөрчлөлтийг заавал төрүүлдэг. Юм үзэж нүд тайлахын хэрээр үзэл бодол, зан авираа тунгааж усыг нь ууж, ёсыг нь дагадаг. Америкт очоод өөрсдийнхөө хэвшил зуршлыг өөрчилсөн байдлыг судлаж үзвэл:

1. Цагийн үнэ цэнийг мэдэж авсан	60.3%
2. Ажил хөдөлмөрийнхөө үнэ цэнийг ойлгодог болсон	52.9%
3. Мөнгийг хэрхэн зарцуулах арвиг занд сурсан	26.8%
4. Хөдөлмөрийнхөө үр шимээр бахархах болсон	20.2%
5. Амралт, чөлөөт цагаа зохицуулж чаддаг болсон	18.4%
6. Харилцааны соёл сайжирсан	18.8%
7. Амьдралынхаа ирээдүйд итгэх итгэл үнэмшил бадарсан	16.5%
8. Сайхан амьдралын утга учрыг ухаарсан	15.8%

гэсэн дараалалтай байна.

IV. Америк дахь монголчуудын амьдрал, бодол

IV.1. Тэд хоорондоо ямар харилцаатай байдаг вэ?

Цагаачдын өлгий гэгддэг америкт очсон хүмүүс улс үндэстэн болгоныхоо ёс жаягаар «америк маягийн амьдрал»-тай зохицон аж төрцгөөж байна. Хятад, Солонгос, Вьетнам гээд хэзээний л нэг газраа бөөгнөрцгөөж, өөрийн гэсэн хороололтой болцгоож, ихэвчлэн улсынхаа үйлдвэрийн бүтээгдэхүүнээр худалдаа наймаа эрхлэж бас зарим нь хар бараан амьдралыг дагнах нь ч буй. Харин монголчууд нэг их бөөгнөрөхгүй ч гэсэн бие биенээ бараадан садан төрөл, найз нөхдийнхөө тус дэмээр болцгоож л байх юм.

Судлагдагсадын 43.6 хувь нь найз нөхөд, садан төрлийн харилцааг голлон, 30.4 хувь нь «хувиа борлуулж» амьдарцгаадаг гэжээ. Америкт байгаа монголчуудын хооронд «тусархаг найрсаг харилцаа илүүтэй байдаг» гэж 22.5 хувь нь үзсэн байна.

Монголчууд ганцаараа байхдаа орон дээрээ хэвтэж гансран бодлогоширдог, хоёулаа байхаар архи уудаг, гурав дөрвүүл болохоор нанчилддаг гэсэн 1970-1980 аад оны үед гадаадад суралцаж байсан оюутны тухай дэгс ярианы цаг үе өнгөрч хаана ч гэсэн эвтэй найртай болж байх шиг. Солонгост амьдардаг монголчуудын талаар эвгүй зүйл сонсогддог боловч үнэндээ тэдний дотор найрсаг тусархуу зан давамгай байдгийг тэнд удаан жил амьдарсан олон хүнээс сонсож байсан билээ.

Америкт байгаа монголчууд хоорондоо тун эвтэй найртай, ядарсан нэгэндээ тус болох гэсэн эрмэлзэл ямагт байдгийг мэдэх юм. Интернет, утас, факс болон найз нөхдийн ярианаас хэн нэгнийхээ тухай сонсоцгоож энд тийм ажил байна, түүнд тийм зовлон болж гэдгийг мэдээд хэр хэмжээгээрээ тусалцгаадаг л юм билээ.

Улсын баяр наадмыг тухайн хотдоо зохион байгуулахдаа бөхийн барилдаан, уралдаан тэмцээн, урлагийн тоглолтыг заавал явуулдаг уламжлал нэгэнтээ тогтжээ. Цагаан сараар боломжийн байрыг хөлслөн авч хадаг, хөөрөгөө солилцож бууз, боов амсацгааж хэнээс ч дутахааргүй цагаалцгаадаг юм.

Нэрд гарсан дуучид, жүжигчдийн тоглолтыг ч аятайхан зохион байгуулахыг тэд л хариуцаж байдаг. Харин эдгээр тоглолтын чанар чансаанд сэтгэл төдийлөн сайн байдаггүй бололтой. Судлагдагсадын 35-38.4 хувь нь эдгээр тоглолтод бизнесийн сонирхол давамгайлдаг гэсэн боловч монголчуудтайгаа уулзах боломж олгодог (24.0%), тэдний тоглолтоор нутгаа санасан сэтгэлээ дэвтээдэг (14.6%), сайхан тоглолт болдог (12.5%) учир үзэж сонирхдог байна.

Ер нь америкт амьдарч буй монголчууд амьдралын утга учрыг сайтар ойлгож, эх орныхоо хөгжлийн ирээдүйд итгэл дүүрэн амьдарцгааж байна.

IV.2. Ар гэртээ үзүүлж буй тэдний дэмжлэг

Аав, ээж, ах, дүү садан төрлийн холбоог эрхэмлэн хүндэлдэг уламжлал бидний хэнд нь ч мөнх оршдог. Чухамхүү энэ сэтгэлийн үүднээс ураг төрлөөрөө өөдтэйхөн амьдрах эрмэлзэлтэйгээр алс холыг зорьцгоодог билээ. Америк, Солонгос, Чех; ер гадаадын аль ч оронд ажиллаж амьдарч байгаа үр хүүхэд, ах дүүсийн «гуйвуулсан мөнгө» манайхны амьдралд мэдэгдэхүйц нэмэр болдгийг хэн хүнгүй мэднэ. Тодорхой айл өрхөд төдийгүй улсын валютын нөөцөд ч нөлөөтэй нь мэдээж. Манай судалгаанд хамрагдагсадын далан таван хувь нь ар гэртээ мөнгө явуулдагас 57.6 хувь нь жилдээ 1000 хүртэл, 10.6 хувь нь 1001-3000, 7.9 хувь нь 3001-5000 доллар явуулдаг байна. Энэ боломжийн мөнгө, ялангуяа долларын ханш тэнгэрт тулж буй одоо үед бүр ч их нэмэртэй зэрэгцээ «хувийн болон хувьсгалын үйл хэрэг»-т ач тустай. Ажил хөдөлмөрийнхөө цалин хөлснөөс илүүчилсэн хэд гурван мөнгийг манайхан юунд хэрхэн, зохистой зарцуулж байгааг бас бодох л зүйл.

IV.3. Тэд хэдийд эх орондоо буцах вэ?

Нүүдэлчин амьдрал, нүүдэлчдийн сэтгэл нэвт шингэсэн мөртлөө заавал төрсөн нутаг руугаа тэмүүлэх нь монгол хүн болгонд төрөхөөс заяагдсан юм шиг. Аль ч улс оронд суурьшин тэнд насаараа үхэн үхэтлээ амьдардаг нь гадаадынханд нийтлэг жишиг байдаг. Харин монголчууд бол ёстой үгүй: заавал эх орондоо буцах хүсэлтэй байдаг. Даяаршлын хязгааргүйдэл, ёс заншлын задгайрал, хойч үеийн хүсэл сонирхлын хувьслаас энэ уламжлал алсын ирээдүйд өөрчлөгдөж магадгүй ч, бараг үгүй байхаа. Ямар ч л байсан ойрын ирээдүйд ийм байдал илрэхгүй бололтой.



АНУ-д суурьшин амьдарсан хугацаанаас дээрх хариулт хамааралтай боловч ерөнхийдөө нийтлэг шинжтэй юм. Тэдний дийлэнхийг нь эзлэж байгаа ойрын таван жилийн дотор багтаж нутагтаа буцна гэж хариулагсад ихэвчлэн удаан хугацаагаар оршин суусан хүмүүс байна.

Америкийг зорих монголчуудын гол зорилго бол ажиллахын зэрэгцээ суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амьдралын нөхцлөө

сайжруулах гэр бүлээ тэжээх гэсэн эрмэлзэл байдгийг дээр дурдсан билээ. Монголдоо боломжийн амьдрах нөхцөл бүрдүүлчихээд (41.1%), бизнес эрхлэх хэмжээний мөнгө хуримтлуулчихаад (27.2%) монголдоо буцна гэж хариулагсад өндөр хувьтай байгаагийн зэрэгцээ байр, машиний мөнгө цуглуулж аваад буцна гэсэн хүмүүс бас байна. Судлагдагсадын дөрвөн хүний нэг нь (25.2%) ийм байдлаар төлөвлөөгүй байлаа. Харин эндээ амьдрана гэсэн хүмүүс бараг байхгүй (0.3%) байна.

Хэзээ нэгэн цагт монголын үр сад «хүний нутагаас эрдмийг өвөртлөн ирэх» төдийгүй улс орноо хөгжүүлэх, ажил мэргэжил эзэмшин ахуй амьдралаа дээшлүүлэх арга ухаанд суралцсан «бие ухаан жагссан хүмүүс» болж ирээд эх орныхоо хөгжил дэвшилд дорвитой хувь нэмэр оруулах нь лавтай.

IV.4. Монголоос хэнийг татаж авах хүсэлтэй байдаг вэ?

Манай монголчууд гадаадад амьдарч дасч идээшсэний дараа боломж олдвол (боломж гаргаад) өөрсдийнхнөө татаж авахыг ямагт хичээж байдаг. Бидний судалгаанд хамрагдсан америкт байгаа монголчуудын 59.2 хувь нь гэр бүлийнхээ хамт (21.6 хувь нь эхнэр “нөхөр”, хүүхдийн хамт, 4.2 хувь нь гэр бүл, хүүхэд, аав ээжийн хамт) амьдардаг байна. Тийм ч учраас ах, эгч, дүүгээ татаж авах хүсэлтэй хүмүүс хамгийн өндөр (52.5%) хувийг эзлэж байна. Энэ хүсэл эрмэлзэллээ биелүүлэхийн төлөө хөөцөлдөж бараг бүтээчихсэн хүмүүс (25.2%) байгаа хэдий ч зөвхөн бодож төлөвлөхөөс хэтрээгүй хүмүүс (43.2%) зонхилж байгаа юм.

Мөрөөдлийн төдий байсан америкт монголчууд ирж очих нь ердийн зүйл болсон төдийгүй тэдний иргэн болсон (судлагдагсадын 24.4 хувь нь манай садан төрөл, танил хүмүүс АНУ-ын иргэн, эсвэл ногоон карттай болсон гэж хариулжээ). Мөн тэнд төрж өссөн хүүхдүүдийн тоо ч олширч байна.

Гадаадад зорчих, амьдрах эрх боломж нээгдээд удаагүй байгаа ч монголчууд дэлхийн тив болгонд суурьшин амьдарч, амьдрах амьдрахдаа аль ч улс үндэстнээс дутахааргүй амьдарч, ажиллаж чадаж байгаа нь бидний бахархал. Мэдлэг боловсрол, соёл хүмүүжил, ажиллах ур чадвар, амьдрах ухаан эзэмшсэн шинэ үе монголын хөгжлийн ирээдүйг авч явах болно. Урьдын юм ул болж шинэ юм зул болж байна.